



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Хараат бус аудиторын тайлан.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ...	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4-5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7-8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
4. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
5. Аудитын илрүүлэлт .....	12
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14



**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлдөгчийн Хурал
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн Газар
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
НББ	Нягтлан Бодох Бүртгэл



ТЭСИЙН-ИЛЧ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛ А.ГАЛБАДРАХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Тэсийн-Илч ХХК-ийн борлуулалтын орлого өмнөх оноос 58.9 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Нягтлан бодох бүртгэлд ашиглаж байгаа Leader программ нь байгууллагын үйл ажиллагааны онцлогтой бүрэн нийцэхгүй байгаагаас борлуулсан барааны өртөг, борлуулалт удирдлагын зардлыг зөв хуваарилаагүй байна. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Данс	2021 оны 01-р сарын 01	2021 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,548,905.12	23,304,041.55
1.1.2	Дансны авлага	19,251,601.00	15,484,358.00
1.1.6	Бараа материал	40,046,030.00	56,599,789.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	766,690.00	300,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	69,613,226.12	95,688,189.05
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,303,822,844.97	3,131,354,612.82
1.2.2	Биет бус хөрөнгө	18,152,000.00	18,152,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,321,974,844.97	3,149,506,612.82
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,391,588,071.09	3,245,194,801.87
2.1.1.1	Дансны өглөг	253,400.00	54,998.88
2.1.1.3	Татварын өр	4,140,806.92	5,950,865.65
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	597,256.07
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,394,206.92	6,603,120.60
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,394,206.92	6,603,120.60
2.3.1	Өмч: - төрийн	3,632,203,450.00	3,632,203,450.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	211,418,021.51	252,570,821.51
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	95,124,931.00	158,653,522.58
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(551,552,538.34)	(551,552,538.34)
2.3.10		0.00	(253,283,574.48)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,387,193,864.17	3,238,591,681.27
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	3,391,588,071.09	3,245,194,801.87

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
31	Борлуулалтын орлого (цэвэр)	348,011,769.48	399,435,667.17
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	522,730,637.58	594,562,852.03
3	Нийт ашиг (алдагдал)	(174,718,868.10)	(195,127,184.86)
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	124,942,411.00	200,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	56,606,632.00	57,269,591.00
11	Санхүүгийн зардал	113,099.17	86,798.62
12	Бусад зардал	11,924,600.00	1,000,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	70,550.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(118,491,338.27)	(253,283,574.48)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(118,491,338.27)	(253,283,574.48)



21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(118,491,338.27)	(253,283,574.48)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(118,491,338.27)	(253,283,574.48)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00



## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	384,656,064.84	443,476,429.99
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	384,208,538.00	442,941,429.99
	Бусад мөнгөн орлого	447,526.84	535,000.00
1.2	Мөнгөн зарлага (-)	375,982,679.92	423,030,973.56
	Ажиллагчдад төлсөн	134,708,163.00	152,565,377.54
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	41,581,111.68	46,738,492.16
	Бараа материал худалдан авахад төлсөн	88,418,091.00	87,593,958.50
	Ашиглалтын зардалд төлсөн	45,938,461.00	55,181,140.26
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	27,902,928.34	41,915,811.00
	Татварын байгууллагад төлсөн	30,414,991.73	33,401,565.48
	Даатгалын төлбөрт төлсөн	63,750.00	63,750.00
	Бусад мөнгөн зарлага	6,955,183.17	5,570,878.62
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,673,384.92	20,532,456.43
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	6,690,320.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	6,690,320.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	-6,690,320.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000.00	0
	Төлсөн ногдол ашиг	10,000,000.00	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,326,615.08	13,755,136.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,875,520.20	9,548,905.12
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,548,905.12	23,304,041.55

## 2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021		Биелэлт	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Ажилчдын тоо</b>	<b>24</b>	<b>25</b>	<b>-1</b>	<b>104.2</b>
2	<b>Нийт БО</b>	<b>377,463,800.0</b>	<b>399,435,700.00</b>	<b>(21,971,900.00)</b>	<b>105.8</b>
	Цалингийн	168,703,400.0	168,678,600.00	24,800.00	100.0
	НДШЗ	26,013,600.0	25,924,900.00	88,700.00	99.7
	Тэтгэмж	6,525,000.0	6,825,000.00	(300,000.00)	104.6
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,320,000.0	6,320,000.00	-	100.0
	Гэрэл цахилгаан	44,065,700.0	45,062,600.00	(996,900.00)	102.3
	Түлш халаалт/нүүрс/	49,335,000.0	62,099,500.00	(12,764,500.00)	125.9
	Бичиг хэрэг	700,000.0	647,800.00	52,200.00	92.5
	Тээвэр шатахуун	11,864,000.0	15,628,400.00	(3,764,400.00)	131.7
	Нүүрс тээвэр	13,000,000.0	15,408,900.00	(2,408,900.00)	118.5
	Интернэтийн төлбөр, Шуудан холбоо	1,307,800.0	1,332,900.00	(25,100.00)	101.9
	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	1,500,000.0	1,264,700.00	235,300.00	84.3
	БҮТЭЗ	250,000.0	156,800.00	93,200.00	62.7
	Хоол хүнс	4,896,000.0	5,781,100.00	(885,100.00)	118.1
	Хөдөлмөр хамгаалал	11,318,000.0	10,133,700.00	1,184,300.00	89.5
	Урсгал засвар, үйлчилгээ	3,622,200.0	3,850,800.00	(228,600.00)	106.3
	Сэлбэг хэрэгсэл	3,666,000.0	3,836,400.00	(170,400.00)	104.6
	Дотоод албан томилолт	800,000.0	766,000.00	34,000.00	95.8
	Аудитын төлбөр	600,000.0	-	600,000.00	0.0
	Үйлдвэрийн зориулалтаар ус ашигласны төлбөр	350,000.0	329,000.00	21,000.00	94.0
	Усны шинжилгээний төлбөр	329,200.0	146,400.00	182,800.00	44.5
	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.0	65,000.00	20,000.00	76.5



	Тээврийн хэрэгслийн даатгал	80,000.0	63,700.00	16,300.00	79.6
	Тээврийн хэрэгслийн агаарын бохирдол	10,500.0	9,500.00	1,000.00	90.5
	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.0	33,000.00	-	100.0
	ЭХЗЗ-ийн үйлчилгээний хөлс	1,132,391.4	1,132,400.00	(8.60)	100.0
	ҮХХ-ийн албан татвар	459,500.0	459,500.00	-	100.0
	Газрын төлбөр	80,000.0	80,000.00	-	100.0
	Программын лиценз Архив	331,000.0	231,000.00	100,000.00	69.8
	Хог хаягдлын хураамж	50,000.0	50,000.00	-	100.0
	Банкны шимтгэл	100,000.0	74,500.00	25,500.00	74.5
	Гамшгаас хамгаалах/ БЭЗ/	3,774,638.0	3,774,400.00	238.00	100.0
	ЭХ-ийн зардал	11,387,200.0	8,574,900.00	2,812,300.00	75.3
	ТУЗ-ийн зардал	3,774,638.0	3,701,300.00	73,338.00	98.1
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>376,463,767.4</b>	<b>392,442,700.00</b>	<b>(15,978,932.60)</b>	<b>104.2</b>
	<b>Ашиг алдагдал</b>	<b>1,000,032.6</b>	<b>6,993,000.00</b>	<b>(5,992,967.40)</b>	<b>699.3</b>

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Үйл ажиллагаа

Тэсийн-Илч ХХК нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ. Компани нь 2011 оноос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 103 дугаар тогтоолоор Тэсийн-Илч ХХК болон өөрчлөгдсөн байна. Тус компани нь 25 үндсэн ажилтантай ТУЗ-ийн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан халаалт үйлдвэрлэх, түгээх
- Цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулах

#### 3.2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 67-р тогтоолоор Тэсийн илч ХХК-ны дүрмийг шинэчлэн баталсан.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Тэсийн-Илч ХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.



Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагадах аргаар бүртгэж тайлагнадаг

Тус компани нь Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Санхүүгийн тооцоолох групп ХХК”-ийн Leader программ хангамжийг ашигладаг бөгөөд компанийн үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй байна. Тухайлбал: Өртөг зардлыг зөв хуваарилж бүртгэх боломжгүй, гар ажиллагаа ихтэй зэрэг дутагдал байна.

### 3.4 Зорилтот түвшин, төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн 02 дугаар тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 377.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 377.5 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 1.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлээр 399.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 392.4 сая төгрөгийн зардал гаргаж 6.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт №1 Зорилтод түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2021 он		Биелэлт	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Ажилчдын тоо	24	25	-1	104.2
2	Нийт борлуулалтын орлого	377,463.8	399,435.7	(21,971.9)	105.8
3	Нийт зардал	376,463.8	392,442.7	(15,978.9)	104.2
4	Ашиг алдагдал	1,000.0	6,993.0	(5,993.0)	699.3

Тайлант онд борлуулалтын орлогын төлөвлөгөөг 21.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийт зардлыг 18.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь дараа оны нүүрсний нөөцийг бэлтгэсэнтэй болбоотой байна. Цаашид нүүрсийг их хэмжээгээр нөөц үүсэхгүй байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан худалдан авалт хийх нь тохиромжтой гэж аудитаар үзлээ.

Бүтэц орон тооны хувьд 1 орон тоог нэмэгдүүлэн ажилласан нь аж ахуй нэгж, айл өрхийн усны хэрэглээг төрөөс төлөх болсонтой холбогдуулан түүрээсээр ажиллуулдаг гүний худгийн түгээгчийг компанийн орон тооны ажилтан болгож цалинжуулан ажиллуулсантай холбоотой байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 146.4 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар буурч 3,245.2 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,548.9	23,304.0	(13,755.1)
Авлага	19,251.6	15,484.4	3,767.2
Бараа материал	40,046.0	56,599.8	(16,553.8)
Үндсэн хөрөнгө	3,303,822.8	3,131,354.6	172,468.2
Биет бус хөрөнгө	18,152.0	18,152.0	0.0



<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,391,588.1</b>	<b>3,245,194.8</b>	<b>146,393.3</b>
Өр төлбөр	4,394.2	6,603.1	(2,208.9)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,387,193.9	3,238,591.7	148,602.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,391,588.1</b>	<b>3,245,194.8</b>	<b>146,393.3</b>

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 9.5 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 443.2 сая төгрөгийн орлого орж 429.5 сая төгрөгийн зардлыг гаргаж 23.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын эхний үлдэгдэл 19.2 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 3.7 сая төгрөгийн авлагыг барагдуулж ажилласан бөгөөд 15.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ авлага нь уурын зуух туршилтын журмаар ажиллаж халаалт түгээж байх үед үүссэн бөгөөд өдийг хүртэл авлага барагдаагүй байна. Уг авлагыг барагдуулахаар холбогдох байгууллагуудыг 2021 онд шүүхэд шилжүүлсэн байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 40.0 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 15.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дараа онд ашиглах нүүрсний нөөцийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансанд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 28.7 сая төгрөгийн усны машин, эрүүл мэндийн төвийн ашиглаж байсан 29.8 сая төгрөгийн барилга байгууламжийг шилжүүлэн авсан, худалдаж авсан 6.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, дахин үнэлж үнэ тогтоосон 41.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна. Тайлант онд үнэ тогтоохоор данснаас хассан 45.8 сая төгрөгийн хөрөнгө болон 283.6 сая төгрөгийн элэгдлийн зардлын дүнгээр үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан байна. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 172.5 сая төгрөгөөр буурч 3,131.4 сая төгрөг болсон байна.

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 4.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 6.6 сая төгрөг болж 2.2 сая төгрөгийн НӨАТ-ын өглөгөөр нэмэгдсэн байна.

### **3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа**

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2021 онд гүйцэтгэх захирлыг томилгоо, шаардлагатай зардал гаргах, хөрөнгө хүлээн авах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний гүйцэтгэл санхүүгийн тайлангийн аудит, 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг 3.8 сая төгрөг байхаар баталсан байна. Цэцэрлэг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Тэсийн-Илч ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилсон байна. Тэсийн-Илч ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдэд тайлант онд нийт 3.8 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.



## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өр төлбөрийг барагдуулах, НББ-ийн бодлогын баримт бичиг, программ хангамжийн шинэчлэлийг хийлгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, хоёр дахь шатны хяналтыг дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангаа Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн программ хангамж нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Тус компанийн дотоод хяналтын нэгж 3 гишүүнтэй бөгөөд 2021 онд 7-н чиглэлээр хяналт хийхээр төлөвлөн ажиллаж 5 зөрчил илрүүлж илэрсэн зөрчлийг арилгуулж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 546.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **4.5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тэсийн-Илч ХХК нь 2021 онд нийт 98.4 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

##### **4.5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тэсийн-Илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

### **5. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 108.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 101.4 сая төгрөгийн алдааг залруулж, 6.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Тус компани нь 101.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа бусад орлогоор хүлээн зөвшөөрснийг дахин үнэлгээний нэмэгдэл болон эздийн өмчийн бусад хэсэгт дансанд залруулан бүртгэсэн.

#### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй

#### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй.



#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, программ хангамж нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна. Тухайлбал хөрөнгийн өртөгт тээвэр, бэлтгэл, хөгжүүлэлтийн зардлыг шингээх, капиталжуулах, зардлыг өртгийг борлуулсан барааны өртөг, борлуулалт удирдлагын зардалд хэрхэн хуваарилах талаар тусгаагүй, санхүүгийн программ гар ажиллагаа ихтэй зэрэг дутагдал байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн программыг үйлдвэрлэл эрхэлж буй онцлогтойгоо уялдуулж өөрчлөлт оруулах.

##### 2. Өр төлбөртэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Өмнөх оны НӨАТ-ын өглөгийн үлдэгдэл 4.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант оны эцэс НӨАТ-ыг дутуу тооцоолсны улмаас 2.2 сая төгрөгийн өр төлбөрийг нэмж үүсгэсэн бөгөөд нийт 6.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр үйлийн 8/ "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн болон "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Өр төлбөрийг барагдуулж, НӨАТ-ыг зөв тооцож өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

##### 3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 158.6 сая төгрөгийн хөрөнгөөр компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх өөрчлөлтийг хийж улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлээгүй байна. Энэ нь "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" заалттай нийцэхгүй байна. Мөн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэлтэй хөрөнгөөр компанийн өмчийг нэмэгдүүлж хуулийн этгээдийн хувийн хэргийг шинэчлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Тэсийн-Илч ХХК	4	108.0	1	101.4					3	6.6
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>108.0</b>	<b>1</b>	<b>101.4</b>					<b>3</b>	<b>6.6</b>

## АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО:



### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2020 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл</b>	3,632,203,450.00	0.00	0.00	211,418,021.51	95,124,931.00	(251,295,485.29)	3,687,450,917.22
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	(300,257,053.05)	(300,257,053.05)
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>2021 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл</b>	3,632,203,450.00	0.00	0.00	211,418,021.51	95,124,931.00	(551,552,538.34)	3,387,193,864.17
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	(253,283,574.48)	(253,283,574.48)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	41,152,800.00	63,528,591.58	0.00	104,681,391.58
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	3,632,203,450.00	0.00	0.00	252,570,821.51	158,653,522.58	(804,836,112.82)	3,238,591,681.27